



ОЮУНЫ ӨМЧИЙН ГАЗРЫН ДАРГЫН ТУШААЛ

2020 оны 05 сарын 08 өдөр

Дугаар А/94

Улаанбаатар хот

Г.Буяндэлгэрийн ажлын цагийн горимыг өөрчлөх тухай

Засгийн газрын агентлагийн эрх зүйн байдлын тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.3.1 дахь заалт, мөн зүйлийн 8.4 дэх хэсэг, Гамшгаас хамгаалах тухай хуулийн 10 дугаар зүйлийн 10.4.2 дахь заалт, Засгийн газрын 2020 оны 2 дугаар сарын 02-ны өдрийн “Бэлэн байдлын зэрэгт шилжүүлэх тухай” 62 дугаар тогтоол, Засгийн газрын 2020 оны 2 дугаар сарын 19-ний өдрийн “Бэлэн байдлын зэрэгт шилжүүлсэн хугацааг сунгах тухай” 64 дугаар тогтоол, Засгийн газрын 2020 оны 4 дугаар сарын 29-ний өдрийн “Бэлэн байдлын зэрэгт шилжүүлсэн хугацааг сунгах тухай” 147 дугаар тогтоолыг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1. Барааны тэмдгийн шинжээч Ган овогтой Буяндэлгэр нь бага насны хүүхэдтэй тул коронавируст халдвараас урьдчилан сэргийлэх, эрсдлийг бууруулах, бага насны хүүхдийн аюулгүй байдлыг хангах зорилгоор 2020 оны 5 дугаар сарын 08-ний өдрөөс эхлэн 2020 оны 05 дугаар сарын 29-ний өдрийг дуустал гэрээсээ цахимаар ажиллах нөхцлөөр хангаж, ажлын цагийн тусгай горимд шилжүүлсүгэй.

2. Г.Буяндэлгэрт Улсын онцгой комисс, Эрүүл мэндийн яамны шийдвэр зөвлөмжийг дагаж мөрдөх, албан үүргээ бүрэн гүйцэтгэж байгууллагын үйл ажиллагааг доголдуулахгүй ажлаа зохион байгуулахыг үүрэг болгосугай.

3. Г.Буяндэлгэрийн хоолны нөхөх төлбөрийг холбогдох журмын дагуу тус тус тооцож олгохыг нягтлан бодогч /Э.Оюунцэцэгт/-т зөвшөөрсүгэй.

4. Г.Буяндэлгэрийн ажлын гүйцэтгэл, үр дүнг тооцож ажиллахыг Аж үйлдвэрийн өмчийн хэлтсийн дарга/ С.Урангэрэл/-д, тушаалын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Захиргаа удирдлагын хэлтсийн дарга / С.Ганзориг/-д тус тус даалгасугай.

ДАРГА

Ц.АЗБАЯР

000478